



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 04 сарын 22 өдөр

Дугаар А/БЗФ

Улаанбаатар хот

**Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын  
эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2020 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 28,352,990 /хорин найман сая гурван зуун тавин хоёр мянга есөн зуун ерэн/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар /Д.Баянбат/-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгөнөөс 3 нэр төрлийн 22,810,000 /хорин хоёр сая найман зуун арван мянган/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устгах, 9 нэр төрлийн 5,542,990 /таван сая таван зуун дөчин хоёр мянга есөн зуун ерэн/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Өмчийн ашиглалт, удирдлагын газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар /Д.Баянбат/-т үүрэг болгосугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг үнэлж, худалдан борлуулах ажлыг зохион байгуулахыг Урт цагаан үйлчилгээ, аж ахуйн төв /П.Батжаргал/-д үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

11500000377

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын  
 даргын 2020 оны 04 дугаар сарын 22 өдрийн  
 0/137 дугаар тушаалын хавсралт

Байгууллагын нэр: Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар

төгрөгөөр

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ЭБХХХК-ын хурлын шийдвэр
<b>Машин, тоног төхөөрөмж</b>										
1	Цагийн бүртгэл	5	ш	1	385,000	385,000	385,000	-	ажиллагаагүй	татах
2	Dell vostro 230	4	ш	1	715,000	715,000	715,000	-	ажиллагаагүй	татах
3	Компьютер DeLL 3010 мт	5	ш	1	900,000	900,000	900,000	-	ажиллагаагүй	татах
4	Компьютер Optiplex	5	ш	2	990,000	1,980,000	1,980,000	-	ажиллагаагүй	татах
5	Rapasonic утасны аппарат	10	ш	1	52,021	52,021	52,021	-	ажиллагаагүй	татах
Машин, тоног төхөөрөмжийн дүн				6		4,032,021	4,032,021			
<b>Тавилга, эд хогшил</b>										
6	Бичгийн ширээ	10	ш	1	294,664	294,664	294,664	-	эвдэрсэн	татах
7	Дарга ширээ/Орлогч/	10	ш	1	273,976	273,976	273,976	-	эвдэрсэн	татах
8	Хэлтсийн даргын ширээ	10	ш	2	351,579	703,157	703,157	-	эвдэрсэн	татах
9	Хүлээлгийн сандал	10	ш	1	239,172	239,172	239,172	-	эвдэрсэн	татах
Тавилга, эд хсгшлын дүн				5		1,510,969	1,510,969			
<b>Бусад үндсэн хөрөнгө</b>										
10	Ногооны хүлэмж	10	ш	9	2,500,000	22,500,000	22,500,000	-	эвдэрсэн	устгах
11	Санхүүгийн программ	4	ш	1	190,000	190,000	190,000	-	ажиллагаагүй	устгах
12	Архивын онлайн програм	5	ш	1	120,000	120,000	120,000	-	ажиллагаагүй	устгах
Бусад үндсэн хөрөнгийн дүн				11		22,810,000	22,810,000			
<b>Нийт данснаас хасах хөрөнгийн дүн</b>						<b>28,352,990</b>				
Үүнээс: Татан төвлөрүүлэх хөрөнгө						5,542,990				
Актлах хөрөнгө						<b>22,810,000</b>				